

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР ИЛГЭЭХ ДАРААЛАЛ

1. WWW.mcis.gov.mn сайтад хандаж тусгай зөвшөөрөл цэсний холбогдох баримт бичгээс СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА-тай танилцах, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, **барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх**, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”, Барилгын материал үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагатай танилцах
2. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь төрийн мэдээллийн сангуудтай холбогдсон тул тус цахим программд бүртгүүлэх инженер, техникийн ажилтнууд E-MONGOLIA платформд бүртгүүлсэн байх
3. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл СУНГАЛТ болон НЭМЭЛТЭЭР хүссэн ААНБ-н ИТА-нууд тус байгууллагад сүүлийн 3 сар тасралтгүй нийгмийн даатгал төлсөн байх
4. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл ШИНЭЭР хүссэн ААНБ-ын ИТА-нууд тус байгууллагад сүүлийн 1 сар тасралтгүй нийгмийн даатгал төлсөн байх
5. **Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн ААНБ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ тохирлын баталгаажуулалтанд завал хамруулсан байх**
6. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл СУНГУУЛАХ, НЭМЭЛТЭЭР хүссэн ААНБ-ууд нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл ажиллагааны мэдээ мэдээллүүдийг /БХБ-ын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 206, А/184 тоот тушаалын мэдээлэл авах холбогдох маягт 3-БМ-1, 3-БМ-2, 3-БХБЯ-1, 3-БХБЯ-2 маягтын дагуу тайлангаа хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлнэ. (Үйл ажиллагаа явуулаагүй бол үйл ажиллагааны “Х”-ээр ирүүлнэ). Маягтын загварыг www.bmat.mn сайтаас татаж авч, bmaterial.tz@gmail.com хаягаар цахим хэлбэрээр БХТ-ийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс болон МБМҮХолбоонд хагас, бүтэн жилээр тогтмол илгээж, БМҮТЗ-ийн хавсралтад тэмдэглэгээ хийлгэсэн байх
7. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны үйлчилгээний хөлс /420,000 төгрөг + ажлын төрөл, экспертизийн багийн зардлаас хамаарна/

Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн нэг цэгийн
үйлчилгээ

Утас: 316253, 99262172, 99143658, 99015759

**Барилга, хот байгуулалтын яаманд / Монголын Барилгын материал
үйлдвэрлэгчдийн холбоо/ -д**

Тусгай зөвшөөрөл хүсэх тухай

Манай аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хүрээнд дараах аж ахуйн үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авах, /сунгах, сэргээх/ хүсэлтээ илэрхийлж байна.

Үйлдвэрлэх бүтээгдэхүүн нэр төрөл:

МҮ-

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн бичиг баримт нь үнэн зөв бөглөгдсөн , шаардлагатай тохиолдолд үйлдвэрийн талбай болон тоног төхөөрөмж, машин механизмыг үзүүлэхэд бэлэн болно.

Манай аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөл авах бүтээгдэхүүн нь шаардлагатай технологийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, норм дүрмийг мөрдөж, мэргэжлийн өндөр түвшинд үйлдвэрлэгдэх бөгөөд тусгай зөвшөөрөлтэй холбогдсон хууль тогтоомжид заасан үүрэг, хариуцлагыг хүлээх болно.

Аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж:

Захирал /

Гарын үсэг

тэмдэг

огноо